



**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 05 өдөр

Дугаар A/32

Улаанбаатар хот

┌ Монголын хүүхдийн спортын зуны ┐
VIII наадмын хүрээнд Баянзүрх
дүүргийн өсвөр үеийн аварга
шалгаруулах Хөл бөмбөгийн тэмцээн


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 34 дүгээр зүйлийн 34.6 дахь хэсэг, Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны А/285 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд Баянзүрх дүүргийн өсвөр үеийн аварга шалгаруулах Хөл бөмбөгийн тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Дотоод хэргийн их сургуулийн гадна талбайд зохион байгуулсугай.

2. Тэмцээний зардалд 2,377,500 (Хоёр сая гурван зуун далан долоон мянга таван зуу) төгрөгийг Нэмэлт санхүүжилтийн зардлаас гаргахыг Нягтлан бодогч (П.Бат-Оюун)-д зөвшөөрсүгэй.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Спортын хэлтсийн дарга (Ю.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНСҮРЭН

Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/32 тушаалын хавсралт



ТӨСӨВ

2025 оны 05 дугаар сарын 05

Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын хүрээнд
Баянзүрх дүүргийн өсвөр үеийн аварга шалгаруулах Хөл бөмбөгийн тэмцээн

№	Спортын тэмцээний төрөл	Хэзээ	Хаана	Зардлын нэр төрөл		Жин, зай, насны ангилал тус бүрээр		Багийн дүн			Нийт	
				шагнал	Нийт: эр-12, эм-12	Тоо ширхэг	Нэгж үнэ	Тоо ширхэг	Нэгж үнэ	Тоо	Үнэ	
1	Хөлбөмбөгийн өсвөр үеийн аварга дүүргийн аварга шалгаруулах тэмцээн	2025 оны 04 дүгээр сарын 24-нд	15-н талбайд	Өргөмжлөл	72	12,500	3	12,500	75	937,500		
				Шүүгч	15	80,000	-	-	15	1,200,000		
Нийт дүн: 2,377,500												